



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань сумын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/039/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 99013699 Цахим  
хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

аудитор: Д.Мөнхтулга

Утас: 99031809 Цахим хаяг: munkhtulgad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



## ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2025.1.31 № 02/05

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЧАНДМАНЬ СУМЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Ш.ПҮРЭВДАМБА ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чандмань сумын Сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чандмань сумын Сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Тайлант онд 6 болон 12 дугаар ангийн хүүхдүүдэд үдийн хоолоор үйлчилсний орлогыг байгууллагын дансаар дамжуулаагүй, хувь хүний дансаар дамжуулан зарцуулсан,
- Хүүхдийн үдийн хоолны материалыг данс бүртгэлд тусгаагүй,

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 45 дугаар зүйлийн 45.2-д "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", 45.2.1-д "нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ" 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.5-д "бүх орлого" гэсэн заалтуудыг мөрдөөгүй иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Өр төлбөр өсөх болсон шалтгаан нь сургуулийн бүсийг утасгүй интернэтээр хангах санхүүгийн түрээсийн гэрээг 21,348.0 мянган төгрөгөөр байгуулсантай холбоотой байна.

### Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 247,580.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авсан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР



## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>150,570,266.43</u></b>	<b><u>136,160,009.97</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	65,954,293.79	62,610,651.69
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	65,954,293.79	62,610,651.69
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	65,954,293.79	62,610,651.69
31211	Төрийн сангийн харилцах	65,954,293.79	62,610,651.69
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	14,525,907.93	15,760,108.57
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,640,992.20	2,606,647.84
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	10,884,915.73	13,153,460.73
3351	Байгууллагаас авах авлага	8,075,713.73	8,075,713.73
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,809,202.00	5,077,747.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	70,090,064.71	57,789,249.71
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	620,000.00	1,134,300.00
35130	Эм боох материал	620,000.00	1,134,300.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	69,470,064.71	56,654,949.71
35410	Бичиг хэргийн материал	377,000.00	308,000.00
35420	Аж ахуйн материал	47,770,699.71	50,375,749.71
35460	Хүнсний материал	21,322,365.00	5,971,200.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,951,236,913.30</u></b>	<b><u>2,112,884,487.35</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,951,236,913.30	2,112,884,487.35
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,889,966,913.30	2,051,726,987.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,958,639,167.00	2,047,034,267.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(345,235,142.84)	(413,805,027.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	672,922,629.40	829,687,156.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(514,655,137.82)	(561,046,024.49)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	256,303,616.31	306,322,006.61
39208	Хуримтлагдсан элэгдэл	(179,446,997.09)	(198,129,169.53)
39217	Ном	41,438,778.34	41,663,778.34
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	61,270,000.00	61,157,500.00
39301	Программ хангамж	1,057,000.00	1,057,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(607,000.00)	(719,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	60,820,000.00	60,820,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,101,807,179.73</u></b>	<b><u>2,249,044,497.32</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,408,674.00</u></b>	<b><u>16,369,187.01</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,408,674.00	16,369,187.01
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,408,674.00	16,369,187.01
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	574,809.01
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,163,384.00	14,782,996.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	245,290.00	1,011,382.00
41361	Байгууллагад төлөх өглөг	84,200.00	621,892.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	161,090.00	389,490.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,100,398,505.73</u></b>	<b><u>2,232,675,310.31</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,100,398,505.73	2,232,675,310.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	627,621,997.00	627,621,997.00
51101	Өмч: - төрийн	627,621,997.00	627,621,997.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	429,361,364.45	561,638,169.03
51210	Өмнөх үеийн үр дүн	429,361,364.45	429,361,364.45
51220	Тайлант үеийн үр дүн	-	132,276,804.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,043,415,144.28	1,043,415,144.28
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,101,807,179.73</u></b>	<b><u>2,249,044,497.32</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,707,924,948.00</b>	<b>2,410,035,572.40</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>85,787,148.00</b>	<b>264,796,272.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	85,787,148.00	264,796,272.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	85,787,148.00	264,796,272.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	165,900.00	1,561,955.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,078,548.00	15,654,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	84,542,700.00	247,580,017.40
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,622,137,800.00</b>	<b>2,145,239,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,406,750,600.00	1,866,271,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,406,750,600.00	1,866,271,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	215,387,200.00	278,967,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	215,387,200.00	278,967,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,633,122,284.09</b>	<b>2,277,758,767.82</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,633,122,284.09</b>	<b>2,277,758,767.82</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,585,402,740.71	2,229,548,827.82
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,021,041,556.64	1,467,364,135.93
210101	Үндсэн цалин	753,873,631.54	969,964,538.54
210102	Нэмэгдэл	230,255,562.71	452,241,889.39
210104	Урамшуулал	36,912,362.39	45,157,708.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	126,116,355.75	182,859,972.44
210201	Тэтгэврийн даатгал	87,362,965.99	126,515,699.09
210202	Тэтгэмжийн даатгал	10,277,995.88	14,696,939.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,181,886.45	7,620,332.72
210204	Ажилгүйдлийн даатгал	1,744,704.89	6,800,052.99
210205	Эрүүл мэндийн даатгал	19,548,802.54	27,226,948.12
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	213,590,006.62	276,922,052.00
210301	Гэрэл, цахилгаан	33,334,006.62	10,591,352.00
210302	Түлш, халаалт	179,256,000.00	266,215,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	115,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,335,936.50	14,371,452.00
210401	Бичиг хэрэг	472,000.00	4,676,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,863,936.50	9,694,852.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	69,734,280.00	84,412,035.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	115,200.00
210502	Хоол, хүнс	69,734,280.00	84,296,835.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	350,000.00	-
210604	Урсгал засвар	350,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,160,000.00	27,619,847.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	10,879,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,160,000.00	16,740,447.10
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	147,074,605.20	175,999,333.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,092,690.00	29,241,890.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,815,400.00	13,002,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	111,166,515.20	133,755,443.35
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	47,719,543.38	48,209,940.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	47,713,350.00	47,862,940.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47,713,350.00	47,862,940.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	6,193.38	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,193.38	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	347,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	347,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>74,802,663.91</b>	<b>132,276,804.58</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>74,802,663.91</b>	<b>132,276,804.58</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	627,621,997.00	1,043,415,144.28	354,558,700.54	2,025,595,841.82
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	627,621,997.00	1,043,415,144.28	354,558,700.54	2,025,595,841.82
C07	Тайлант үеийн үр дүн			74,802,663.91	74,802,663.91
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	627,621,997.00	1,043,415,144.28	429,361,364.45	2,100,398,505.73
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	627,621,997.00	1,043,415,144.28	429,361,364.45	2,100,398,505.73
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	627,621,997.00	1,043,415,144.28	429,361,364.45	2,100,398,505.73
D08	Тайлант үеийн үр дүн			132,276,804.48	132,276,804.48
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	627,621,997.00	1,043,415,144.28	561,638,168.93	2,232,675,310.21

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,623,382,248.00</b>	<b>2,162,455,555.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,244,448.00</b>	<b>17,216,255.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,244,448.00	17,216,255.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,244,448.00	17,216,255.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	165,900.00	1,561,955.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,078,548.00	15,654,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,622,137,800.00</b>	<b>2,145,239,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,406,750,600.00	1,866,271,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,406,750,600.00	1,866,271,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	215,387,200.00	278,967,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	215,387,200.00	278,967,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,534,763,180.74</b>	<b>2,165,799,197.10</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,534,763,180.74</b>	<b>2,165,799,197.10</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,487,255,937.36</b>	<b>2,117,589,257.10</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,018,247,924.24	1,464,508,000.00
210101	Үндсэн цалин	710,285,156.74	948,266,832.19
210102	Нэмэгдэл	263,106,884.50	470,348,693.42
210104	Урамшуулал	44,855,883.00	45,892,474.39
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	130,493,600.00	183,063,500.00
210201	Тэтгэврийн даатгал	88,735,800.00	124,483,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,439,400.00	14,645,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,351,500.00	7,322,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,088,200.00	7,322,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,878,700.00	29,290,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	213,981,006.62	276,360,400.00
210301	Гэрэл, цахилгаан	8,117,006.62	10,029,700.00
210302	Түлш, халаалт	204,864,000.00	266,215,700.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	115,000.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	80,149,700.00	72,247,710.00
210502	Хоол, хүнс	80,149,700.00	72,247,710.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,400,000.00	2,260,000.00
210604	Урсгал засвар	1,400,000.00	2,260,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,079,700.00	38,073,647.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	274,700.00	11,493,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,805,000.00	26,580,447.10
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	37,904,006.50	81,076,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,988,996.50	67,065,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,915,010.00	14,010,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>47,507,243.38</b>	<b>48,209,940.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	47,501,050.00	47,862,940.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47,501,050.00	47,862,940.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	6,193.38	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,193.38	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	347,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	347,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>88,619,067.26</b>	<b>(3,343,642.10)</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>32,158,500.00</b>	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>32,158,500.00</b>	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	32,158,500.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	32,158,500.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(32,158,500.00)</b>	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	56,460,567.26	(3,343,642.10)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	9,493,726.53	65,954,293.79
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	65,954,293.79	62,610,651.69

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,221,826,100.00	2,165,452,197.10
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,221,826,100.00	2,165,452,197.10
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,171,157,500.00	2,117,589,257.10
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,492,745,400.00	1,464,508,000.00
210101	Үндсэн цалин	1,040,943,800.00	948,266,832.19
210102	Нэмэгдэл	420,657,400.00	470,348,693.42
210104	Урамшуулал	31,144,200.00	45,892,474.39
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	186,593,200.00	183,063,500.00
210201	Тэтгэврийн даатгал	126,883,300.00	124,483,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,927,600.00	14,645,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,463,700.00	7,322,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,463,700.00	7,322,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,854,900.00	29,290,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	276,567,400.00	276,360,400.00
210301	Гэрэл, цахилгаан	10,029,700.00	10,029,700.00
210302	Түлш, халаалт	266,215,700.00	266,215,700.00
210303	Цэвэр, бохир ус	322,000.00	115,000.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	88,127,300.00	72,247,710.00
210502	Хоол, хүнс	88,127,300.00	72,247,710.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,400,000.00	2,260,000.00
210604	Урсгал засвар	2,400,000.00	2,260,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	42,420,200.00	38,073,647.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,550,400.00	11,493,200.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	28,869,800.00	26,580,447.10
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	82,304,000.00	81,076,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,293,700.00	67,065,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,010,300.00	14,010,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	50,668,600.00	47,862,940.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	50,668,600.00	47,862,940.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	50,668,600.00	47,862,940.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,221,826,100.00	2,162,108,555.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,866,271,900.00	1,866,271,900.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,866,271,900.00	1,866,271,900.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	278,967,400.00	278,620,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	278,967,400.00	278,620,400.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	76,586,800.00	17,216,255.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,783,600.00	1,561,955.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,654,300.00	15,654,300.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	62,148,900.00	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>65,954,293.79</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>62,610,651.69</b>
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	61	60
620001	Удирдах ажилтан	4	4
620002	Гүйцэтгэх ажилтан	37	36
620003	Үйлчлэх ажилтан	20	20
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>61</b>	<b>60</b>
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	41	40
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1	1
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	1	1
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17	17

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 123,746.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ.

Залруулагдаагүй нийт 123,746.2 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 123,746.2 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 1,213.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 122,532.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант онд хэрэгсэн сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн зардлыг төсөвт буцаан төвлөрүүлээгүй, албан хаагчид илүү цалин олгоод авлагаар бүртгээгүй 1,213.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-д “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1-д “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

### **3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **3.2.1 Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тайлант онд хүүхдийн үдийн хоолонд 47,862.9 мянган төгрөгийн хүнсний материалыг худалдан авч шууд зардалд бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ”, 14.42-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж үдийн хоолны хүнсний материалыг данс бүртгэлд тусган тооцоог сар бүр бодож хэвших

#### **3.2.2 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тайлант онд дотуур байрны хүүхдийн хоол хүнсэнд 72,247.7 мянган төгрөгийн хүнсний материалыг шууд гэрээ байгуулан худалдан авсан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоосон тогтоолын дагуу босго үнээс давсан барааг худалдан авахдаа худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллах

#### **3.2.3 Орлого данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тайлант онд 6 болон 12 дугаар ангийн хүүхдэд үдийн хоолоор үйлчилсний 2,422.0 мянган төгрөгийн орлогыг байгууллагын данс бүртгэлд тусгаагүй, хувь хүний дансаар дамжуулан зарцуулсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ”, 14.4.2-д “бүх орлого” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүүхдийн төлбөртэй хоолны орлогыг сургуулийн дансаар дамжуулан санхүүгийн тайланд бүрэн тусган ажиллах

### **3.2.4 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш санхүүжилтийн орлогыг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуульд заасан хугацаанд холбогдох мэдээллийг үнэн зөв байршуулан Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Чандмань сумын сургууль	Алдаа илэрээгүй	0	0	0	0			0	0				
<b>Нийт дүн</b>		<b>0</b>	<b>0.00</b>	<b>0</b>	<b>0.00</b>			<b>0</b>	<b>0.00</b>				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Чандмань сумын сургууль	Сүү хөтөлбөрийн хүрээнд хэмнэгдсэн зардлыг төсөвт төвлөрүүлээгүй	1	887.4	1	887.4						
	Ажилчидад илүү олгосон цалинг төсөвт төвлөрүүлээгүй	0	326.2	0	326.2						
	Үдийн хоолны зардалд хяналтыг хэрэгжүүлээгүй	1	47,862.9					1	47,862.9		
	Үдийн хоолны орлогыг данс бүртгэлд тусгаагүй	1	2,422.0					1	2,422.0		
<b>Нийт дүн</b>		<b>3</b>	<b>51,498.5</b>	<b>1</b>	<b>1,213.6</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>50,284.9</b>	<b>0</b>	<b>-</b>

## 4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
Чандмань сумын сургууль	Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй	1	72,247.7					1	72,247.7
	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй	1	-					1	0
<b>Нийт дүн</b>		<b>2</b>	<b>72,247.7</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>72,247.7</b>

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ						1		
<b>НИЙТ</b>		<b>1</b>	<b>1</b>						